





Сургуулийн өмнөх
боловсролын байгууллагын
багшид зориулсан



Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг, чадвар олгох сургалтын модуль



ШАР НОМ



Бага насны хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр

1:

2:

3:

4:

Миний бие /25 минут/	Сайн уу, муу юу аль нь вэ? /25 минут/	Миний биеийн аюулгүйн дүрэм /25 минут/	Би өөрийгөө хамгаалж чадна /25 минут/
Миний бие бол миний л бие	Тааламжтай болон тааламжгүй мэдрэмж	Итгэлтэй хүмүүс	Танихгүй хүн
“Хөшөө” хөдөлгөөнт тоглоом	Миний биеийн хүрч болох, болохгүй хэсэг	Нууц	Хаалгаа хэнд тайлах вэ?
Цэцэн дүүтэй болсон нь	Аюулын дохио	Аюулгүйн гурван дүрэм	Мэргэн аргаа олцгооё

ХИЧЭЭЛ 1:

МИНИЙ БИЕ БОЛ МИНИЙ Л БИЕ

Хичээлийн зорилго:

Хүүхэд өөрийгөө болон бие эрхтнээ таньж мэдэх

Өөрийн бие эрхтнээ хайрлах, хамгаалахад суралцах;

Өөрийн биеийн нууц хэсэг, мөн бусдын биеийн нууц хэсгийг харах болон хүрч болохгүй гэдгийг мэдэх.

Үйл ажиллагааны дараалал:

Хүүхдэд хамгийн сонирхолтой бөгөөд ойлгомжгүй зүйл нь хүүхэд өөрөө байдаг. Хүүхэд өөрийнхөө биеийг бусадтай харьцуулан төсөөтэй болон ялгаатай байдлаа олж хардаг. Би хэн бэ? Би ямар байна вэ? Би юу хийж чадах вэ? Миний нүд, чих ямар үүрэгтэй юм бол? гэх мэт олон асуултуудын хариултыг өөрөө олж авч чадахгүйд хүрдэг. Энэ үед тэдэнд өөрийнхөө онцлог, давуу талыг мэдрэх нөхцөл боломж олгоорой.

Хүүхдүүд хивс болон сандал дээр хагас тойрог болон сууна.

Хэрэглэгдэхүүн:

- Зураг, зурагт үзүүлэн
- Хос хүүхэлдэй
- Самбар
- Шоо

Сэдэлжүүлэлт:

Багш зураг (Зураг 8) ашиглан:

Амьтад хоолондоо яаж хүрэх талаар ярилцана. Зургийг хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх, тэдний мэдлэгийг тодруулах, зорилгоор ашиглана.

Загас, морь, төөлүүр хорхойд зэрэг амьтны аль эрхтэн нь хоолондоо хүрэхэд тусалсан бэ?



Үйл ажиллагаа 2: “Хөшөө” хөдөлгөөнт тоглоом

Энэхүү тоглоомыг 15-20 хүүхдийн оролцоотой тоглоно. Тоглоомыг хөгжилтэй, сонирхолтой, хүүхэд бүр идэвхтэй оролцохоор зохион байгуулах нь чухал. Тоглоомын дүрмийг тайлбарлаарай.

Хүүхдүүд өвдөг өндөр өргөж, танхим дотор ийш тийш чөлөөтэй алхана. Алхах явцдаа багшийн хэлэх үгийг анхааралтай сонсоод өгүүлбэрийг үргэлжлүүлэн гүйцээж хэлнэ.

Жишээлбэл:

Хурдан гүйхэд гэхэд хүүхдүүд *хөл хэрэгтэй* гэх мэтчилэн шүлгээ эхлээд давтана.

Хурдан гүйхэд...	хөл хэрэгтэй
Холыг харахад ...	нүд хэрэгтэй
Урлан бүтээхэд...	гар хэрэгтэй
Үлгэр сонсоход ...	чих хэрэгтэй

Энэ тоглоомонд оролцож байгаа хүүхэд бүр

Ямар нэгэн хөшөө болж хувирна уу гэж хүүхдүүд бүгд нэгэн зэрэг чанга дуугаар хэлж, янз бүрийн хөшөө болж хувирна. 2-3 удаа тоглохдоо хүүхэд бүр өөрийн хүссэн дүрд хувирч тоглоно. (Тоглох явцад багш хүүхдүүд хэн нэгнийг дууриахгүй өөрийнхөөрөө байхад нь анхаараарай)

Багш хүүхдүүдээс:

Хөшөө бүр ижилхэн байна уу?

Яагаад янз бүр байна вэ?

Хэн бидний биеийг хөдөлгөөд байна вэ? асууж ярилцана.

Дээрх үйл ажиллагаа, бататгах тоглоомоос хүүхдүүд биеийн эрхтэн бүр үүрэгтэй, хэрэгтэй, үнэ цэнэтэй гэдгийг мэдэрнэ.

Үйл ажиллагаа 3: Цэцэн дүүтэй болсон нь

Зураг 9



Зураг дээр байгаа зүйлийн тухай зонхилж ярилцаарай. Дараах үзүүлэнг (Зураг 9)-ыг ашиглан Цэцэн, Мэргэн хоёрыг яагаад ийм хувцас өмссөн тухай ярилцаарай. Хүүхдүүд биеэ хамгаалахын тулд янз бүрийн орчинд (гадаа, анги танхимд, гэртээ усанд орохдоо...) хувцсаа тохируулан өмсдөгийг мэдэх боловч биеийн нууц хэсгийг далдлах зорилгоор дотуур хувцас өмсдөгийг төдийлөн мэддэггүй. Энэ ойлголтыг **“Цэцэн дүүтэй болсон нь”** эхийг ашиглан тайлбарлаж өгөөрэй.

Хүүхдүүдэд “Цэцэн дүүтэй болсон нь” эхийг уншиж өгнө (Зураг 10).

Цэцэн охин бяцхан дүүтэй болжээ. Цэцэн дүүтэй болсон баяраа хуваалцахаар Мэргэн найзыгаа гэртээ урилаа. Аав ээж хоёр нь дүүг нь хуурайлах үед шодойг нь олж харсан Цэцэн маш их гайхлаа.



Багш, хүүхдүүдэд Цэцэн охины түүхийг уншиж өгөх явцдаа түр зогсолт хийж:

Хүүхдүүдээ, Цэцэн яагаад гайхсан юм бол?

Харин Мэргэн гайхсан болов уу? Яагаад? Та нар юу гэж бодож байна? гэсэн асуултуудыг тавьж, харилцан ярилцана.

Багш үргэлжлүүлэн эхийг уншиж өгнө.

...Тэгээд яагаад өөрийнхөөс нь өөр байгааг ээжээсээ асуужээ. “Эрэгтэй, эмэгтэй хүний бие нь адил боловч хүйс нь өөр байдаг. Энэ бол бидний нууц эрхтэн юм. Эрэгтэй хүний нууц эрхтнийг “шодой”, эмэгтэй хүний нууц эрхтнийг умдаг гэдэг. Хүний биеийн энэ хэсэг хамгийн нандин эрхтэн учир бусдад хамаагүй үзүүлж болохгүй. Байнга дотуур хувцас өмсөн далдалж хамгаалдаг юм. Тиймээс биеийнхээ энэ хэсгийг хэн нэгэнд харуулж, хүргэж болохгүй. Мөн бусдын нууц хэсгийг харж, хүрч болохгүй шүү гэж ээж нь тайлбарлаж өгчээ.

Шаардлагатай тохиолдолд дахин давтан уншиж тайлбарлаж өгнө.

Үүний дараа эрэгтэй, эмэгтэй хүүхдийн биеийн ялгааг харуулсан хүүхэлдэй болон зурагт үзүүлэнг ашиглан биеийн нууц эрхтнүүдийг эрхтэн тогтолцооны (анатомийн) нэрээр нь нэрлүүлнэ.

Нэгдүгээр хичээлийн төсгөлд хүүхэд өөрийн биеийн нууц хэсгийг хэн нэгэнд харуулах болон хүргэж болохгүй, мөн бусдын нууц хэсгийг харах болон хүрч болохгүй гэдгийг ойлгосон эсэхийг бататган асууж, ойлгоогүй тохиолдолд

Зураг 9-ыг ашиглан биеийн нууц хэсгийг хамгаалах ёстой тухай дахин тайлбарлана.

БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ:

1

Дээрх бүлэг сэдэв нь “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн “өөрийгөө мэдрэх ойлгох”, “хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах” зэрэг чадваруудыг олгоход дэмжлэг үзүүлж байгааг анхаарч, үйл ажиллагааг зохион байгуулаарай.

2

“Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-т багшийн үүрэг оролцоог доорх байдлаар тодорхойлсон:

- Хүүхдийг нэрээр нь дуудаж харилцана.
- Хүүхдийн сэтгэл санааны байдлыг мэдэрч ойлгох, хүндэтгэлтэй харилцана.
- Хүүхэд өөрийгөө болон бие эрхтнээ таньж мэдэхтэй холбогдсон сэдвийн хүрээнд үйл ажиллагаануудыг зохион байгуулна.
Жишээ нь: Миний бие
- Хүүхдийн асуулт, хүсэл эрмэлзэлд ач холбогдол өгч хариулж, биелүүлнэ, гаргасан санал санаачлагыг дэмжинэ.
- Шаардагдах ном, зураг, үзүүлэн таниулах материал, тоглоом, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл болон бусад бүтээгдэхүүнийг бэлтгэж, хүүхдэд чөлөөтэй ажиллах боломж олгоно.
- Хүүхдийн асуулт бүрт ач холбогдол өгч, хариултыг хамтран хайж олно.
- Хүүхдэд уур уцаараа хянах аргуудыг зааж өгч үлгэрлэн дагуулна
- “Миний бие бол миний л бие” сэдвийн агуулгыг бататгахдаа хөгжүүлэх тоглоом №1-2 тоглуулаарай.

Хөгжүүлэх тоглоом N° 1

“ Хувцаслая”

Зорилго:

Нууц эрхтнийг эрхтэн тогтолцооны (анатомийн) нэрээр нэрлэх, хамгаалах ойлголтыг бататгах

Хэрэглэгдэхүүн:

Цэцэн, Мэргэн хоёрын хувцасгүй зураг (Зураг 11).

Дотуур болон гадуур хувцасны зураг

Хайч, цавуу

Аргачлал:

Хүүхдүүд хэнийг хувцаслах, ямар хувцсаар хувцаслахаа өөрсдөө сонгон авна.

Сонгосон хувцсыг хайчлан авч биеийн зурагт тохируулан наана.

Мэргэн, Цэцэн хоёрын аль нэгийг сонгон авч хувцасласны дараа хүүхдүүдтэй ямар хувцас

өмсгөсөн, биеийн аль хэсгийг далдалсан гэх зэргээр асууж ярилцан, тэдний ойлголт мэдлэгийг бататгана.

Хүүхдэд өөрийнхөөрөө үйлээ төлөвлөх, төлөвлөснөө хэрэгжүүлэх, зохион бүтээх, сонголт хийх боломж олгоорой.

Зураг 11



Тоглоомон дасгалыг хичээлийн үндсэн хугацаанд оруулахгүйгээр төвийн үйл ажиллагаагаар зохион байгуулна.

Хөгжүүлэх тоглоом N° 2

“Найзуудын нэг өдөр” (Зураг 12)

Хэрэглэгдэхүүн:

Тоглоомын зураг бүхий хөлөг, нүүдэл хийх 2-4 ширхэг тоглоом (хүүхэлдэй, шагай, шатрын хүү байж болно), шоо 1 ширхэг

Үйл ажиллагаа:


Багштайгаа хамтран болон бие даан 2-4 хүүхэд “Та битгий уурлаарай” тоглоомыг дүрмийн дагуу тоглоно. Өглөөнөөс орой болтол 36 буудал бүхий замыг туулж, түрүүлж барианд хүрсэн нь ялна.

Тоглоомын дүрэм:

- 1 Хүүхдүүд хэн эхэлж нүүхээ хайч, чулуу, даавуу тоглоомоор тоглож шодно.
- 2 Эхний хүүхэд шоог орхиж, нарны зураг бүхий гараанаас эхэлж, шооны нүхний тоогоор урагш нүүнэ.
- 3 Дарааллын дагуу шоог хаяж тоглоно.
- 4 Цас болон борооны зураг бүхий буудалд буувал өнжинө.
- 5 Ногоон сумны дагуу урагш замаа товчилж, улаан сумны дагуу ухарч нүүнэ.
- 6 Түрүүлж барианд ирсэн нь хожно.

"Найзуудын нэг өдөр"

Зураг 12



ХИЧЭЭЛ 2:

ХОЁРДУГААР ХИЧЭЭЛ: САЙН УУ, МУУ ЮУ АЛЬ НЬ ВЭ?

Хичээлийн зорилго:

Хүүхэд биеийн аль хэсэгт хүрч “болох”, “болохгүй” талаар мэдэх, асуудлыг бие даан өөрсдийнхөө хэмжээнд шийдвэрлэхэд нь тусламж үзүүлэх

Өөрийгөө илэрхийлэх, бусдыг мэдэрч ойлгоход дэмжлэг үзүүлэх

Хүүхэд өөрийн биеийн нууц хэсгийг бусдад харуулах, хүргэж болохгүй гэдгийг анхаарах, мөн бусдын нууц хэсгийг харах, хүрч болохгүй гэсэн ойлголтыг бататгах.

Хэрэглэгдэхүүн:

Зурагт үзүүлэн (Зураг 4-15)

Чонын баг-1ш

Үйл ажиллагаа 1: Тааламжтай болон тааламжгүй мэдрэмж

Хүүхдэд өөрийнхөө бие, сэтгэлийн тааламжтай ба тааламжгүй байдлыг мэдрэх, илэрхийлэх, тулгарсан асуудлыг бие даан өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэхэд нь туслахад дараах үйл явдлыг ашиглаарай.

Хүүхдүүд хивс болон сандал дээр хагас тойрог болон сууна. Багш Цэцэн охин нагац ахтайгаа мэндчилж буй зургийг үзүүлэн, тайлбарыг хэлнэ. (Зураг 13)

Зураг 13



Цэцэн охины гэрт нагац ах нь хааяа ирдэг. Тэр Цэцэн охинтой гар барин мэндэлдэг. Цэцэн охин ахтайгаа хамтдаа шагай нясалж, оньсого таалцаж тоглодог.

Хүүхдүүдэд зургийг ажиглах боломж олгоно. Багш үргэлжлүүлэн нагац ах Цэцэнг үнсэхээр завдаж буй зургийг үзүүлж:

Зураг 14



Нэгэн өдөр нагац ах нь түүнийг чанга тэврэн үнсэхийг завджээ гэсэн тайлбарыг хэлнэ. (Зураг 14)

Хоёр зургийг сайн ажиглуулаад Цэцэн охинд ямар үед тааламжтай, ямар үед тааламжгүй байгаа талаар ярилцаж, хүсээгүй байхад биед нь хүрсэн байна. Чанга тэврч, өвтгөсөн, үнсэхээр завдсан тул тааламжгүй мэдрэмж төрсөн гэдэг ойлголтод хүрнэ.

Ямар үед та нарын биед хүн хүрэхэд тааламжтай байдаг вэ? гэж асууж, сэтгэгдлийг нь яриулна. Дараах зургуудыг ашиглан тааламжтай мэдрэмжийн тухай ойлголтыг бататгаж болно. (Зураг 15-19)



Зураг 15



Зураг 16



Зураг 17



Зураг 18



Зураг 19

Тэгвэл ямар үед тааламжгүй мэдрэмж төрдөг вэ? Тааламжгүй мэдрэмж төрвөл яах вэ? гэх зэргээр ярилцаж, дараах зургуудыг ээлжлэн гаргаж, тааламжгүй мэдрэмжийн тухай ойлголтыг бататгана. (Зураг 20-23)



Зураг 20



Зураг 21



Зураг 22



Зураг 23

Хүүхдүүдийн хариултад эмч биед хүрэхэд тааламжгүй байдаг гэсэн санаа гарахгүй бол:

-Эмч биед чинь хүрэхэд ямар байдаг вэ? гэж асуугаарай. (Зураг 24)

Эмч хүүхдийн эрүүл мэндэд нь анхаарал тавьж, өвчлөхөөс сэргийлж, эмчилдэг учир тааламжгүй байсан ч үзүүлэх хэрэгтэй гэдгийг тайлбарлаж өгнө.



Зураг 24

2

Миний биеийн хүрч болох, болохгүй хэсэг¹

Багш:


Чиний биеийн нууц нандин хэсэгт хэн нэгэн хүрвэл ямар санагдах вэ? гэж асуугаад, хүүхдүүдэд усны хувцастай Цэцэн, Мэргэн хоёрын зургийг үзүүлж ажиглуулан, яагаад улаан эсвэл ногоон өнгөөр тэмдэглэсэн тухай ярилцана. (Зураг 25)

Үүний дараа багш хүүхдүүдийн бие дээрх улаан өнгөөр будсан хэсэгт хэн ч хүрч болохгүй. Зөвхөн аав, ээж усанд оруулах үедээ, эмч эмчлэх зорилгоор л хүрч болно. Харин ногоон өнгөөр будсан хэсэгт бусад хүмүүс хүрч болох хэсэг юм гэдгийг тайлбарлаж өгнө.

Дотуур хувцастай эрэгтэй болон эмэгтэй хүүхдийн зургийг тарааж өгнө. Хүүхдүүд өөрт байгаа зураг дээр биеийн хүрч "болох", "болохгүй" хэсгийг улаан, ногоон өнгийн харандаагаар будаж тэмдэглэнэ.

Хүүхдүүдийг зураг будаж байх үед биеийн аль хэсэгт хүрч болох, болохгүй талаар ойлгосон эсэхийг бататган асуух ба ойлгоогүй тохиолдолд дахин тайлбарлан өгч, тухай бүр ойлгуулан, ухааруулахад анхаарч ажиллана.

Зураг 25



3

Аюулын дохио

“Чоно ба ишигнүүд” хөдөлгөөнт тоглоом
Энэ тоглоом нь аюулын дохио хүний биед хэрхэн илэрдгийг мэдрүүлэх зорилготой учир биеийн тамирын хичээлээр хүүхдэд олгодог авхаалж самбаа, хурд, хүчийг хөгжүүлэх тоглоомтой хольж ойлгож болохгүй гэдгийг анхаарна уу.

Хэрэглэгдэхүүн:

Чонын баг

Аргачлал:

Туслах багш чонын баг өмсөж, хүүхдүүдэд харагдахгүйгээр нуугдсан байна. Багш хүүхдүүдэд ишигнүүд болж тоглохыг санал болгоно. Ишигнүүд багшийн дохиогоор танхимаар тарж, зугаална. Чоно гэнэт архиран гарч ирээд, ишигнүүдийг барихаар хөөнө. Хүүхдүүдийг аль болох ийш тийш гүйлгэн, 2-3 минутын турш хөөцөлдөж тоглоно. Чоныг гарч явахад багш хүүхдүүдэд баруун гараа зүрхэн тушаа тавихыг санал болгоно.

Та нарын биед ямар өөрчлөлт оров?
гэж асууж ярилцана.

Багш хүмүүст айдас төрж, аюул тохиолдоход зүрх хүчтэй цохилж, бие чичрэх, хөлрөх, гэдэс базлах, өвдөх гэх мэт тааламжгүй мэдрэмж төрдөг. Хэрэв хэн нэгэн чиний биед хүсээгүй байхад чинь хүрч, өвтгөн, тааламжгүй мэдрэмж төрж, дургүй чинь хүрвэл багш, аав ээж, ах эгчдээ хэлээрэй гэдгийг тайлбарлаж өгөх юм.

Хүүхдүүдээс тэдний биеийн аль хэсэгт хэн хүрч болох болохгүйг асууж, ойлгосон эсэхийг бататгах ба ойлгоогүй тохиолдолд дахин тайлбарлаж өгөөрэй.

Тоглоомон дасгалыг 5-10 минутаас хэтрүүлэхгүй явуулах ба хичээлийн нэг хэсэг болгож явуулаарай.

БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ:

Энэ бүлэг сэдэв нь “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт тусгагдсан сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх: уур цухлаа зохистойгоор (бусдыг гомдоохгүй, түрэмгийлэхгүй) илэрхийлэх” чадварыг олгоход дэмжлэг үзүүлж байгааг анхаарч, үйл ажиллагааг зохион байгуулаарай.

Хэрэв найзууддаа уурлаж, муудалцвал ямар ч тохиолдолд биед нь хүрч болохгүй гэдгийг хүүхдүүдэд хэлж ойлгуулна. Найзыгаа цохих, өшиглөх, уйлуулах, гомдоох зэрэг үйлдэл гаргасан хүүхдүүдэд зориулан “тайвшруулах булан” байгуулж, тайвшрах орчныг бүрдүүлээрэй.

Хүүхдүүдэд биеийн аль хэсэгт хүрч болох, болохгүй талаарх ойлголтыг бататгахын тулд “Эмч”, “Айл гэр” сэдэвт тоглоомуудаас сонгон хамтран тоглоорой.

“Миний бие бол миний бие” сэдвийн агуулгыг бататгахдаа хөгжүүлэх тоглоомын №3-5 тоглуулаарай.

Хөгжүүлэх тоглоом N° 3

Надад юу тохиолдсон бэ? (Зураг 26)

Зорилго:

Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгоход суралцах
Дохио зангаа, нүүрний хувирал, өөрчлөлтүүдийг ажиглаж, ялгааг мэдрэх, суралцах

Аргачлал:

Хүүхдүүд тойрог болон зогсоно. Удирдагч болсон хүүхэд тойргийн захад бүх хүүхдүүдэд харагдах байдлаар зогсоно.

“Би өнөөдөр ийм байна” гэж хэлээд нүүрний хувирал, биеийн хэлээр ямар нэгэн сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэн харуулна.

Жишээлбэл: “Би өнөөдөр ийм л байна” гэж хэлээд 2 гараа хоёр тийш дэлгэн инээмсэглэнэ.

Хүүхдүүд түүнд ямар байгааг нь хэлнэ. (Баярласан, гомдсон... гэх мэт)

Дараагийн хүүхдийг сонгоно. Ээлж дараагаар бүх хүүхдийг тоглож дуустал тоглоом үргэлжилнэ.

Энэ тоглоомыг хэсэг бүлгээр тоглох нь үр дүнтэй бөгөөд өглөөний хүлээн авалт, орой тарахын өмнө тоглоход тохиромжтой.

Зураг 26



Хөгжүүлэх тоглоом N° 4

Сайн уу, муу юу? Аль нь вэ?

Тоглоомын зорилго:

Бусад хүмүүсийн зан авирыг ойлгож, бодол санаа, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх чадварыг дэмжих

Хэрэглэгдэхүүн:

Зураг 27-32 (Харилцааны сайн, муу жишээг харуулсан зурагнууд байх ба багш нэмэлт карт болон цахим үзүүлэн ашиглаж болно)

Хувилбар 1 (Ахлах бүлэгт)

Багш тоглоомын дүрмийг тайлбарлана.

Хүүхдүүдэд ширээн дээрх зурагнуудаас нэг зургийг сонгон өргөж харуулахад, “хүрч болох” үйлдэл хийж байгаа зураг бол хүүхдүүд тааламжтай байдлын илэрхийлэл болгон эрхий хуруугаа дээш өргөж “болно” гэж хэлнэ. Багш дараагийн зургийг өргөж харуулахад “болохгүй” гэсэн үйлдлийг харуулсан зураг бол хүүхдүүд тааламжгүй байдлын илэрхийлэл болгон чигчий хуруугаа дээш өргөж “болохгүй” гэж хэлнэ.


Зураг 28



Зураг 27



Зураг 29



Зураг 32



Зураг 31



Зураг 30

Хувилбар 2 (Бэлтгэл бүлэгт)

Хүүхдүүд хоёр хоёроороо зэрэгцэж зогсоно. Багш зурган картнаас нэгийг өргөж харуулахад хэрэв “хүрч болох” үйлдэл хийж байгаа бол хүүхдүүд гар барилцан найз болно.

Багшийн харуулж буй зурагт “хүрч болохгүй” үйлдлийг дүрсэлсэн бол хүүхдүүд нуруугаа нийлүүлж гомдсон сэтгэлийн хөдөлгөөнийг дүрсэлнэ.

Хөгжүүлэх тоглоом N° 5

“Надад юу тохиолдсон бэ?”

Зорилго:

Дуртай болон дургүй зүйлээ, санал бодлоо илэрхийлэх, хамгаалахад суралцах;

Бусдын сэтгэл хөдлөлийг мэдэрч ойлгох, хариу үйлдэл үзүүлэх, бусадтай зөв харилцахад суралцах.

Хэрэглэгдэхүүн:

Тоглоомд оролцох хүүхдийн тоогоор толгойн зүүлт, нүүрний хувирлыг харуулсан зурган картууд (Зураг 33).

Аргачлал:

Энэ тоглоомыг 8-10 хүүхэд тоглоно. Хүүхдүүд толгойн зүүлтээ зүүж өөд өөдөөсөө харж 2 эгнээ болон зогсоно.

Багш нүүрний хувирлыг харуулсан зурагт картуудыг хүүхдүүдийн толгойн зүүлтэд байрлуулж өгнө. Хүүхдүүд өөдөөсөө харж зогссон хүүхдээс “Надад юу тохиолдсон бэ?” гэж асуухад, өөдөөс нь харж зогссон хүүхэд найзынхаа нүүрний хувирлыг ажиглаад, түүнд юу тохиолдсон болохыг өөрийн бодлоор хэлнэ.

Асуулт тавьсан хүүхэд хариулыг сонсоод үгээр илэрхийлэх буюу өөрийн нүүрний хувирлаар илэрхийлнэ.

Тоглоомын дүрэм:

- 1 Өөрийн толгой дээрх картыг харахгүй
- 2 Өөрийн тоглох ээлжээ хүлээнэ



Зураг 33

ХИЧЭЭЛ 3:

МИНИЙ БИЕИЙН АЮУЛГҮЙН ДҮРЭМ

Хичээлийн зорилго:

Миний биеийн аюулгүйн дүрэмтэй танилцах

Хүүхдүүд өөрт тохиолдсон хэцүү асуудлыг итгэлтэй хүндээ хэлж, тусламж авахад суралцах

Өөрийгөө хамгаалах энгийн аргад суралцах.

Хэрэглэгдэхүүн:

- Баг (танихгүй хүн)
- Зурагт үзүүлэн (15-20 ширхэг)
- Камишибай театр
- “Никита хүүд тохиолдсон явдал” өгүүллэгийн зураг

Үйл ажиллагааны дараалал:

Итгэлтэй хүмүүс

- 1: Хүүхдүүд тойрог болон сууж, багш өөрөө баг өмсөж, танихгүй хүний дүрд тоглоно. Хүүхдүүдэд "Би хэн бэ?" гэсэн асуултыг тавина.

Хүүхдүүдийн хариултыг сонсож ярилцаад, багны цаана сайн ч хүн байж болно, муу ч хүн байж болно. Баг бол бидний сайн танихгүй хүнийг илэрхийлж байгаа учир, танихгүй хүнтэй болгоомжтой харилцахыг хүүхдүүдэд хэлж ойлгуулна.

Дараа нь багш Мэргэн хүүгийн гунигтай байдлыг харуулсан зургийг үзүүлж, доорх асуултуудыг асууж ярилцана. (Зураг 34)

Мэргэн хүү яагаад гунигтай байна вэ?

Түүнд ямар үйл явдал тохиолдсон юм бол?

Мэргэнд юу тохиолдсоныг бид явал мэдэж болох бол?

Мэргэн өөрөө л ярихгүй бол түүнд юу тохиолдсоныг бид мэдэж чадахгүй, тиймээс бас тусалж чадахгүйг ойлгуулна. Ингэж чадсан тохиолдолд багш дахин багаа зүүж:

Мэргэн өөрт юу тохиолдсоноо энэ хүнд (багтай хүнд) хэлж болох уу? гэж асууна.

Багш:

Хэрвээ чамд найзтайгаа муудалцах, гунигтай явдал тохиолдвол чи хэнд хэлэх вэ?

Тэгвэл хэн нэгэн чиний биеийн нууц хэсэгт хүрвэл чи хэнд хэлэх вэ? Яагаад энэ хүмүүст хэлж байгаа вэ?

Хүүхдүүдийн хариулт дээр нэмээд цагдаа, нийгмийн ажилтан², 108³ утсанд хандаж болно гэдгийг хэлж өгнө. (Зураг 35)

Аав, ээж, ах, эгч

Эмээ, өвөө

Багш,

Цагдаа

Нийгмийн ажилтан

Итгэж болох хэн нэгэн

Эдгээр хүмүүсийг итгэлтэй хүмүүс гэнэ. Яагаад гэвэл энэ хүмүүс чамайг хамгаалж, хэн нэгэнд хэцүү зүйл тохиолдсон үед туслахад бэлэн байдаг.

Зураг 34



Зураг 35



2 Нийгмийн ажилтан бол сум/хороо, сургууль дээр хүүхдүүдэд туслахаар ажилладаг мэргэжилтэн юм.

3 108 утас бол ямарч гар утаснаас үнэгүй холбогддог дугаар бөгөөд тэнд хүүхдүүдэд тусалдаг ах, эгч нар ажилладаг учир чи залгаж тусламж авч болно.

“Никитад тохиолдсон явдал”⁴

Багш, хүүхдүүдэд “Никитад тохиолдсон явдал”-ыг Камишибай⁵ аргаар жүжигчлэн уншиж танилцуулна.

Би та бүхэнд Никита хүүд тохиолдсон явдлыг ярьж өгье. Никита найзуудтайгаа гүйж тоглох дуртай, сэргэлэн хүү юмсанж. Тэр ээжийгээ Хоолоо идээрэй! гэж дуудахад хамгийн түрүүнд хоолны ширээний ард сууж байдаг байлаа. Гэвч тэр нэг өдөр Никита ердийнхөөсөө эрт гэртээ орж ирээд, цонхны дэргэд гудамж руу ширтэн санаа алдан суугаад байв.

Багш, хүүхдүүдээс: Хүүд юу тохиолдсон бэ? Та нар юу гэж бодож байна? гэж асууж ярилцаад үргэлжлүүлэн түүхийг уншиж өгнө.

Хэсэг хугацааны дараа ээж нь бүгдийг оройн хоолондоо урилаа. Никита өлсөхгүй байна гэж хэлээд хоолны ширээнд ирж суусангүй. Ээж нь түүнийг өвдсөн байна гэж бодоод, оронд нь хэвтүүлэн бөөрөлзгөнөтэй цай өглөө. Гэвч Никита унтаж чадахгүй эргэж хөрвөөсөөр байв. Эцэст нь тэрээр дахин цонхны хажууд суун, уртаар санаа алдав.

..Чи юунд санаа алдав гэсэн сөөнгө хоолойг Никита сонсов. Түүнийг цочин харахад цонхны хажууд томоо гэгчийн шар шувуу сууж байлаа. Өвгөн шувуу хөлөө зөөн ойртож, хүүг анхааралтай ширтэн:

- *За тэгээд чамд юу тохиолдов? гэж асуув.*
- *Чи хэн бэ?*
- *Би өвгөн шувуу байна. Би зөвхөн маш гунигтай байгаа хүүхдүүд дээр л нисч ирдэг юм. Тэгээд чам дээр ирлээ. Ингэхэд чи яагаад гуниглаав?*
- *Аа, би... Никита дахиад л санаа алдлаа.*
- *Хэрэв чи надад яривал, би чамд тусалж чадна.*
- *Чи надад тусалж чадахгүй ээ. Би нууцыг хадгална гэж амласан юм аа – гэж Никита бараг дуулдахгүй шахам шивнэн хэллээ.*
- *Тэгээд чи энэ нууцаасаа болоод хоолоо ч идэж чадахгүй, унтаж ч чадахгүй байсан юм уу?*
- *Тийм ээ.*
- *Сайн нууц чамайг гунигтай болгодоггүй. Тэгэхээр чи муу нууцтай болсон байна. Зөвхөн муу нууц л хүүхдийг зовоодог. Харин сайн хүмүүс хүүхдүүдийг энэ муу нууцаа хадгалаасай гэж хүсдэггүй.*

Тэгэхэд Никита өвгөн шувуунд нууцаа хэлэхээр шийджээ.

Манай тоглоомын талбай дээр хааяа нэг ах ирдэг. Тэр бидэнтэй машин, унадаг дугуйны талаар ярилцаж, биднийг чихрээр дайлдаг. Өнөөдөр тэр дахиад ирсэн. Тэгээд биднийг чихрээр дайлж, сонирхолтой юм үзүүлье гэсэн. Дима бид 2 хамт явахаар зөвшөөрсөн. Тэр ах бид хоёрыг хэн ч байхгүй байшингийн буланд дагуулж очоод бидний биеийн нууц хэсэгт хүрсэн.

Димаг уйлахад тэр ах бидэнд:

-Та нар өөрсдөө буруутай учир хэн ч та нарт итгэхгүй. Тиймээс хэнд ч битгий хэл гэж загнасан гээд Никита уйллаа.

Өвгөн шувуу хүү рүү ойртоод:

-За, хүү минь чи нууцаа надад хэлсэн чинь маш сайн хэрэг боллоо. Зарим том хүмүүс хүүхдүүдэд муу зүйл хийгээд түүнийгээ нуухыг хүсдэг. Чи хүүхэд учир чиний буруу огт байхгүй. Чамайг хуурч байгаа том хүн л буруутай. Ийм нууцыг хадгалж огт болохгүй. Ямар нэгэн нууцаас болоод чамд аймаар бас гунигтай байвал чи энэ тухай өөрийнхөө итгэдэг хүмүүстээ заавал хэлэх хэрэгтэй. Эдгээр хүмүүс бол чиний аав ээж, багш, өвөө эмээ чинь байж болно.

- Намайг тэд загнавал яах вэ?

- Никита, чи үнэнийг хэлж, тусламж хүсэх хүсэх хэрэгтэй. Хэрэв тэд чамайг загнавал, чамайг анхаарч сонсох дараагийн хүнийг заавал олох хэрэгтэй шүү.

Никита хэсэг бодлогоширсноо:

- Чамд баярлалаа. Би ээждээ хэлнээ гээд гүйж одлоо.

4 Методические рекомендации для родителей, воспитателей и психологов к брошюре “Я могу защитить себя”, Екатеринбург 2013, 20-р тал

5 Камишибай бол ширээний хүүхэлдэйн театрчилсан арга бөгөөд Япон улсад сургалтын үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг арга юм.

Багш Никита хүүгийн шар шувуутай хамт байгаа зураг дээр тогтон:

- Никита ээждээ хэлсэн болов уу? гэж асууна. Хүүхдүүдийн хариултыг сонсож ярилцаад, сүүлийн хуудсыг үзүүлж Никита хүүд юу тохиолдсон болохыг хамтдаа харна.

- Никита яагаад уйтгарласан бэ?

- Никита, ээждээ болсон явдлыг яагаад яриагүй юм бол?

- Хэрвээ чи Никитад тохиолдсонтой адил нөхцөлд орсон бол энэ тухай хэнд хэлэх байсан бэ?

Хүүхдүүдийн хариултыг анхааралтай сонсон харилцан ярилцаарай. Муу зүйлийг нууцалбал аз жаргалтай болгодоггүй, зовоодог. Хэрэв чамайг “Нууцлаарай, хэнд ч хэлж болохгүй” гэж хэлж байвал яасан ч нууж болохгүйг хүүхдүүд ойлгосон бол “Тэгвэл яах нь зөв бэ?” гэсэн дараагийн асуултыг хүүхдүүдэд тавиарай.

Хүүхдүүд багш, цагдаа, эмч, 108 утсанд хэлнэ гэж хариулж байгаа эсэхийг ажиглаж, хэлээгүй бол өмнө үзүүлсэн зурагнуудыг (Зураг 36) харуулж эдгээр хүмүүст хэлэх үү үгүй юу? гэдгийг тодруулан сануулж болно.



Зураг 36

3: Миний биеийн аюулгүйн 3 дүрэм

ДҮРЭМ НЭГ: “ҮГҮЙ, БОЛЬ” ГЭЖ ЧАНГА ХАШХИР!

Хүүхдүүд ээ, хэн нэг хүн чиний биеийн аль хэсэгт хүрч болох вэ? Биеийн аль хэсэгт хүрч болох, болохгүй талаар ойлголтыг давтан ярилцаад, тоглоомын дүрмийг тайлбарлана.

Багш зураг 37 дээрх улаан, ногоон өнгөөр тэмдэглэсэн хэсгүүдийг ээлжлэн заана. Ногоон өнгийн хэсэгт хүрэх үед хүүхдүүд хүрч болно хэмээн үзэж алгаа ташиж илэрхийлнэ. Харин улаан өнгийн дугуй дүрсээр тэмдэглэсэн хэсгүүдэд хүрэхэд хүрч болохгүй хэмээн үзэж “Үгүй, боль” гэж чанга хашхирна. Хэдэн удаа хамтарч давтан тоглосны дараа багш 1-р дүрмийг тайлбарлаж өгнө. (Зураг 37)

Зураг 37



Усанд оруулах, эмчлэхээс бусад нөхцөлд биед чинь ээж аав, эмчээс өөр хэн ч хүрч болохгүй. Хэрэв дээр дурдсан хүмүүсээс өөр хэн нэгэн хүн та нарыг чихэр, бэлэг өгөх, дагуулж явах, эсвэл биеийн чинь хүрч болохгүй хэсэгт хүрэх гэж оролдвол **“ҮГҮЙ, БОЛЬ” ГЭЖ ЧАНГА ХАШХИР!** Энэ бол 1 дүгээр дүрэм.

Хүүхдүүд аль болох өөртөө итгэлтэйгээр чанга хашхирч сурах хэрэгтэй тул хүүхдүүдэд ажиглан давтан хэлж сургаарай.

ДҮРЭМ ХОЁР: “ЗУГТАА”

Багш, хүүхдүүдэд “Мэргэн, Цэцэн хоёр”-т тохиолдсон үйл явдлыг ярьж өгнө. (Зураг 38)

Мэргэн, Цэцэн хоёр найзуудтайгаа гадаа элсэн дээр тоглож байлаа. Гэнэт тэдний дэргэд танихгүй ах ирээд Мэргэн, Цэцэн хоёрыг хамт өөр газар очиж тоглоё гэж хэлжээ. Мэргэн хүү зугтаж, Цэцэн айсандаа уйлаад л зогсоод байв.

- Мэргэн, Цэцэн хоёр ямар үйлдэл гаргаж байна вэ?

- Хэрэв чи байсан бол яах байсан бэ?

- Хэн нь зөв үйлдэл хийсэн бэ?

- Танихгүй хүн ирээд чамтай ярих гэвэл чи яах ёстой гэж бодож байна?

Энэ үед хүүхдүүдийн олонх нь зугтана гэж хэлж байгаа эсэх, хэн нь зугтах хэрэгтэй гэдгийг мэдэхгүй байгаа зэргийг багш сайн анзаарч, хоёрдугаар дүрмийг хэлж ойлгуулна.

Танихгүй хүн юм уу чамд **таагүй санагдсан** хэн нэг хүн та нарыг чихэр, бэлэг өгөх, дагуулж явах, эсвэл биеийн чинь хүрч болохгүй хэсэгт хүрэх гэж оролдвол олон хүнтэй газар руу, эсвэл аюулгүй байж болох газар руу **ЗУГТАА!!!**

Энэ бол 2 дугаар дүрэм.

Уйлах бол асуудлыг шийдвэрлэх арга биш учир аль болох хурдан холдох, зугтах хэрэгтэй.

- За, өөрийгөө хамгаалахын тулд чи юу гэж хэлэх вэ? чангаар хэлээрэй гэх зэргээр давтан, бусдад сонсогдохоор чанга тод хэлүүлж сургахад анхаараарай.

ДҮРЭМ 3: “ИТГЭЖ БОЛОХ ХҮМҮҮСТ ХЭЛ”

Өөрт болон найзуудад нь аюултай байдал тохиолдсон бол **ИТГЭЖ БОЛОХ ХҮМҮҮСТ ХЭЛ!!!**

Энэ бол 3 дугаар дүрэм.



Эсвэл хүүхдийн тусламжийн 108 дугаар руу залгаж бс

Энэ бол 1, 0, 8 гэсэн гурван тоог залгахад өөрт чинь болон найзуудад нь туслах итгэлтэй хүмүүс байдгийг хэлнэ. (Зураг 39)

Багшийн өгөх нэмэлт тайлбар:

Хүүхдүүдээ бүгдээрээ Никита-д тохиолдсон явдлыг эргэн нэг санацгаая. Никита, Дима 2-т муу зүйл хийсэн хүнийг тэр хоёр таньдаг байсан уу? Хүүхдүүдээс таньдаг байсан гэсэн хариулт хэлэх үед дараах тайлбарыг хэлээрэй: Хүүхдүүдээ тэр ах хааяа тоглоомын талбай дээр нь ирдэг байсан гэхээр таньдаг хүн нь байсан байна. Тэгвэл зарим таньдаг хүмүүс хүүхдүүдэд муу зүйл хийдэг байх нь. Тиймээс хэрэв чамд таагүй мэдрэмж төрж байвал таньдаг хүн байсан ч хамаагүй “Үгүй боль” гэж хашхиран, “Зугтааж”, энэ тухай өөр “Итгэж болох” хүмүүст хэлээрэй гэж нэмэлтээр тайлбарлаж өгөөрэй.

БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ:

1

Дээрх үйл ажиллагаа нь Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт тусгагдсан “өөрийгөө мэдрэх, ойлгох”, “хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах” чадваруудыг олгоход дэмжлэг үзүүлж байгааг анхаарч, үйл ажиллагааг баяжуулан зохион байгуулаарай.

2

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт багшийн үүрэг оролцоог:

- Хүүхдэд өөрийгөө хамгаалах, хийсэн үйлдлээ тайлбарлах боломж олгоно.
- Хүүхдийн сэтгэл санаа таагүй байгаа үед сонсох, тэврэх, энхрийлэх зэргээр хайр халамжийг мэдрүүлнэ.
- Хүүхэд өөртөө тохиолдсон асуудлыг аюулгүй л бол өөрөө шийдэхийг санал болгон дэмжинэ, сэдэлжүүлнэ, бэрхшээлийг давж гарахад зоригжуулна.
- Байгальд амьдрах орчинд хүний эерэг болон сөрөг хандаж буй байдал, түүний үр дагаврыг үлгэр, зохиол, бичлэг, зураг ашиглан танилцуулна хэмээн тодорхойлсон.

3

“Миний биеийн аюулгүйн дүрэм”-ийн агуулгыг бататган дараах хөгжүүлэх тоглоомнуудаас (№6-9) хүүхдийнхээ насны онцлогт тохируулан сонгож тоглоорой.

Хөгжүүлэх тоглоом №8 “Итгэлтэй хүмүүс”

Зорилго:

Хүүхдүүд итгэж болох хүмүүсийн талаар мэдэж, өөртөө тохиолдсон явдал, эсхүүл асуудлыг эдгээр итгэлтэй хүмүүст хандаж, хэлэхэд суралцах

Хувилбар 1:

Багш, хүүхдүүдээс хэн нь аав, ээж, цагдаа, нийгмийн ажилтан, 108 утас, багш, эмчийн дүрд тоглох хүсэлтэй байгаа саналыг авна. Энэ үед хэрэглэгдэхүүнийг тусгай ширээн дээр байрлуулсан байна. Дүрээ сонгосон хүүхдүүд өөрийн хэрэглэх баг, өмсгөл, хэрэглэгдэхүүнээ сонгон авч зүүгээд бусад хүүхдүүдийн өмнө хагас тойрог болон зогсоно. Багш хүүхдүүдээс хэн, хэн хаана зогсож байгааг асууж болно. Тоглоомонд оролцох аав, ээж, цагдаа, эмч, багш г.м-ээр ялган таньж байх нь чухал учраас дүрийг тодотгож байгаа хэрэглэгдэхүүнээ сайн бэлдэх хэрэгтэй.

-Хүүхдүүдээ, багшийнхаа тавьсан асуултыг сонсоод, бодож байгаад сонгосон нэг хүнийхээ дэргэд очиж зогсоорой.

Асуулт:

- Чи сайн найзтай боллоо, энэ сайхан мэдээгээ хэнтэй хуваалцах вэ?

- Хэрвээ найз чинь чамайг тоглоомоо өгсөнгүй гээд цохивол чи хэнд хэлэх вэ?

- Хэрэв хэн нэгэн чиний биеийн хүрч болохгүй хэсэгт хүрвэл энэ тухай хэнд хэлэх вэ?

- Гадаа тоглож байхад, танихгүй эгч ирээд хөөрхөн гөлөг үзүүлье гэвэл чи дагаж явах уу? Энэ тухай хэнд хэлэх вэ?

(Багш нар ангид өрнөж буй бодит үйл явдал, тухайн орчиндоо тохируулан асуултууд нэмж зохиож болно)

Хүүхдүүд асуултыг сонсоод баг өмссөн хүүхдүүдээс сонгон очоод гараас нь хөтлөн зогсоно. Сонгосон шалтгаанаа тайлбарлана

Хэрэглэгдэхүүн:

- Цагдаагийн малгай
- Эмчийн малгай, чагнуур
- Өвөөгийн сахал
- Эмээгийн алчуур
- Ээжийн даашиз
- Аавын цамц гэх мэт дүрд орж тоглох боломжтой хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.

Хувилбар 2:

Энэ хүмүүсийг илүү сайн таньж мэдэхийн тулд тэдний дүрийг тодотгосон янз бүрийн зураг харуулж болно. Тухайлбал,

- Цагдаагийн малгай
- Эмчийн малгай, чагнуурын оронд эмчийн халад, малгай
- Өвөөгийн сахлын оронд буурал үс
- Эмээгийн алчуурын оронд таяг гм-ээр өөр өөр зураг сольж харуулах нь хүүхдүүдийн хувьд илүү сайн таних боломжийг нэмж байгаа юм. Цагдаагийн малгайг харсан хүүхэд цэргийн офицер, онцгой байдлын ажилтны малгайтай андуурч болох талтай гм-ээр олон талаас харах нь чухал.

Хувилбар 3:

“Гэр бүл” хүүхэлдэйн багц, камишибай (Зураг 40) театраа ашиглан, жүжигчлэн тоглуулаарай. Хүүхдүүд ээлжлэн асуулт тавих, хариулах зэргээр бие биеэсээ суралцах боломж олгох юм.

Зураг 40



Хөгжүүлэх тоглоом N° 7

“Миний итгэлтэй хүмүүс”

Хувилбар 1 (Зураг 41):

Хүүхдүүд зураасны дагуу хайчлан тоглоомоо бэлдэнэ. Эвлүүлж дуусаад итгэлтэй хүмүүс нь хэн хэн болохыг нэрлэнэ.


Зураг 41



Хувилбар 2 (Зураг 42):

Эвлүүлдэг тоглоомын дүрс бүхий дэвсгэр зургийг хүүхэд бүр авч, төв хэсэгт нь өөрийгөө, эргэн тойрны нэг нэг нүдэнд өөрийн итгэлтэй хүмүүсээ зурна. Дараа нь зураасны дагуу хайчлан эвлүүлдэг тоглоом болгон, эвлүүлж тоглоно.

Зураг 42



Дүгнэлт:

Дүгнэлт: Чамд ямар нэгэн аюул учирвал хэлж, тусламж авч болох итгэлтэй хүмүүс нь чиний гэр бүлийн гишүүд болох аав ээж, эмээ өвөө, ах эгч, багш байхаас гадна цагдаа, эмч, нийгмийн ажилтан, 108 утасны ах эгч нар байна.

Хөгжүүлэх тоглоом N° 8

“Хэнд хэлэх вэ?”

Зорилго:

Хүүхэд өөрт тохиолдсон асуудлыг шийдвэрлэхдээ зөв хүнд хандаж сурах

Хэрэглэгдэхүүн:


Хүрдний суурь, нүүр зураг, итгэлтэй хүмүүсийн зураг, хайч, цавуу, утас

Зураг 43

Багш тухайн орчин нөхцөлд тохируулан асуултуудыг урьдчилан бэлтгэсэн байна. Асуултууд нь хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолддог аюул, бэрхшээлүүдтэй холбоотой байна. Багш асуултаа тавиад хүүхдүүдэд бодох хугацаа өгч, итгэлтэй хүмүүсийн яг хэнд нь хэлэх вэ гэдгээ сонгох боломжийг өгнө.

Тоглоомыг олон хувилбараар тоглож болно. Ахлах бүлгийн хүүхдүүд зургуудыг хайчлан сонголтоо хийн нааж, багштайгаа хамтран хүрдээ холбоно.

Бэлтгэл бүлэгт хүүхдүүд итгэлтэй хүмүүсээ өөрсдөө зураад, хүрдээ бүтээгээд тоглоно.



Сургах тоглоом N°9

“Харилцуур”(Зураг 43)

Зорилго:

Утсаар зөв боловсон ярих чадварыг дэмжих
Хүүхдүүд картон цаас ашиглан гар утас хийнэ.
Мөн тусламжийн утасны дугааруудыг будаж,
хоорондоо ярьж тоглоно.

Зураг 43



ХИЧЭЭЛ 4:

БИ ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛЖ ЧАДНА

Хичээлийн зорилго:

Хүүхдүүд аюулгүй байх дүрэм зохиоход оролцох,
дүрмийг мөрдөх

Өөрийгөө хамгаалах чадварт суралцах;

Аюултай нөхцөлд орвол хэнд, хэрхэн хандах тухай
мэдэж авах

Хэрэглэгдэхүүн:

- Зурагт үзүүлэн 20-27

Үйл ажиллагааны дараалал:

“Танихгүй хүн”

1: Энэ хэсэгт хүүхдүүдийн сайн мэдэх үлгэрүүдийг ашиглан харилцан ярилцахдаа үлгэр бүрийн дараа дүгнэлтийг хийгээрэй. (Зураг 44-46)

Багш үлгэрийн зургийг үзүүлээд ярилцана.

- Хүүхдүүд ээ, Өнхрүүшд юу тохиолдох вэ?
- Яагаад ийм аюулд оров?

Дүгнэлт: Өнхрүүш үнэгийг зальтай гэдгийг мэдээгүй. Хүүхдүүд та нар гэрээсээ хол ганцаараа зугаалж болохгүй.

- Ишигнүүд ямар алдаа гаргасан бэ?
- Ишигнүүд аюулд орохгүй байж болох байсан уу?

Дүгнэлт: Хаалгаа битгий тайлаарай гэсэн бол хэн нэгэнд хаалга тайлж өгөх, харилцах хэрэггүй.

Багш:

Тэгвэл улаан малгайт яагаад аюулд орсон бэ, та нар юу гэж бодож байна?

Дүгнэлт: Танихгүй хүнтэй ярилцаж, гэрээ зааж өгч болохгүй.

Зураг 44



Зураг 45



Зураг 46



2: Мэргэн арга

-Унага яагаад ийм аюултай байдалд орсон бэ? (Зураг 47)

-Тэгвэл унага яаж аврагдсан бэ?

Цэцэн туулай мэргэн арга бодож олсон тул унага найзаа аварч чадсан.

Мөн өөр ямар үлгэрийн баатар аюулаас аврагддаг тухай асууж ярилцаарай. "Маша ба баавгай" үлгэрийн Маша охин авхаалж самбаа гарган зугтаж чаддаг...г.м

Хүүхдүүдээ Унага туулай, чоно хоёрыг өмнө нь таньдаг байсан уу? Хүүхдүүд "үгүй" гэж хэлнэ. Гэтэл туулай түүнд тусалж, харин чоно түүнд муу зүйл хийхээр завдсан. Тэгэхээр таньдаг болон таньдаггүй хүмүүс дотор сайн, муу хүмүүс аль аль нь байдаг гэдгийг үргэлж санаж яваарай.

Үлгэрийн баатрууд аюулд орохгүй байж болох байсан уу?

Тэгвэл бидэнд ямар нэгэн аюул тулгарч болох уу?

Аюулд орохгүйн тулд бүгдээрээ мэргэн арга бодож олцгооё гээд хүүхдүүдтэйгээ хамтран дүрэм зохиогоорой. Бага насны хүүхэд дүрэмд захирагдах, дуртай байдаг. Хэрэв дүрмийг өөрийнх нь оролцоотойгоор зохиовол дуртайяа мөрддөг.

Зураг 47



Мэргэн аргуудын талаар ярилцъя:

Хүүхдүүдээс гарах санал, санаачилгыг сонссоны дараа зураг 48-51 ээлж ээлжээр гаргаж тавиарай.

Зураг 48



Таньдаг, танихгүй ямар ч хүнээс аливаа эд зүйл, бэлэг, чихэр авахгүй байх

Зураг 49



Таньдаг, танихгүй хүн чиний биеийн нууц хэсэгт хүрвэл "Аюулгүйн 3 дүрмээ санаж" үйлдэл хийнэ.

Зураг 50



Аав ээжийнхээ зөвшөөрөлгүй хүнд хаалгаа нээж өгөхгүй байх

Зураг 51



Таньдаг болон таньдаггүй хүмүүс чамайг зодох үед аюулгүйн 3 дүрмээ санаж, өөрийгөө хамгаалах үйлдэл хийнэ.

БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ:

1

Бага насны хүүхэд дүрэм журманд захирагдах дуртай байдаг. Хэрэв дүрмийг өөрийнх нь оролцоотойгоор зохиовол дуртайяа мөрддөг. Дээрх үйл ажиллагаа нь Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт тусгагдсан “дүрэм журмыг ойлгох, мөрдөх” гэсэн тусгай чадварыг олгоход дэмжлэг үзүүлж байгааг анхаарч үйл ажиллагааг зохион байгуулаарай.

2

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр дэх багшийн үүрэг оролцоо:

- Хүүхэд хэрхэн харилцах тухай хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хүүхдийн “яагаад” гэсэн асуултыг хөхиүлэн дэмжинэ, хариултыг хүүхэдтэй хамтран эрж олох үүрэгтэй гэж тодорхойлсныг анхаарч үйл ажиллагааг баяжуулах нь нээлттэй юм.

Хөгжүүлэх тоглоом N° 10

“Хаалгаа хэнд тайлах вэ?”

Хүүхэд бүрд дасгалын хуудас, улаан харандаа өгсөн байна. Хуудсыг ширээн дээр доош харуулан тавина. Багш хүүхдүүдэд анхааралтай ажиглахыг сануулж, Цэцэн охины гэр бүлийнхний зургийг (Зураг 52) 30 секундын турш харуулна.

Дараа нь зургийг нуугаад:

Зураг 52



Энэ бол Цэцэн охины гэр бүл. Цэцэн гэртээ ганцаараа байхдаа хэнд хаалгаа нээж өгөх вэ? Гэрийнхээ хаалгыг нээж өгч болохгүй (танихгүй) хүмүүсийн зургийг чагтаар тэмдэглээрэй гэсэн даалгаврыг өгнө.

Хүүхдүүд танихгүй хүмүүсийн зургийг (Зураг 53) олж чагтаар тэмдэглэнэ.

Зураг 53



Хөгжүүлэх тоглоом N° 11

Хүүхдүүд яаралтай тусламжийн утасны дугааруудыг (Зураг 54) будаж, холбох замаар тусламжийн утасны дугааруудыг тогтооно.

Зураг 54



Хөгжүүлэх тоглоом N° 12

“Улаан малгайт хаана очих вэ?”

Хэрэглэгдэхүүн:


Тоглоомын зураг (Зураг 55), нүүдэл хийх 2 ширхэг тоглоом (хүүхэлдэй, шагай, шатрын хүү байж болно), шоо 1 ширхэг.

Үйл ажиллагаа:

Хүүхдүүд хосоороо “Та битгий уурлаарай” тоглоомын дүрмийн дагуу эмээгийн дээ хүрэх 20 буудал бүхий замыг туулна. Замд нь эерэг дүр болох анчин, эмээ, эсрэг дүр болох чононууд тааралдаж, саадыг туулсаар эмээгийн д хүрч очих юм.

Тоглоомын дүрэм:

- 1 2 хүүхэд тоглож байгаа үед шоог ээлж дарааллын дагуу хаяж тоглоно.
- 2 Ногоон өнгө бүхий тоонууд дээр (3, 7, 8, 16 тоо) очвол “хаана очих гэж байгаагаа чононд хэлээгүй”-д тооцогдож, сумны дагуу замаа үргэлжлүүлэн туулна.
- 3 Улаан өнгө бүхий тоонууд дээр (6, 15) очвол “хаана очихоо чононд хэлсэн” учир сумны дагуу ухарч замаасаа буцна. Бусад тоонууд дээр буувал үсрэх юм уу ухралгүйгээр тоглоомоо үргэлжлүүлнэ.
- 4 Хамгийн эхэнд эмээгийн дээ очсон тоглогч нь ялагч болно.





MGL DESIGN
PROFESSIONAL PRINTING COMPANY

“Эм Жи Эл Дизайн” компанид хэвлэв.
www.mgl-design.mn

2019 он